



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, СТРАТЕГИ

Хүний нөөцийн хөгжлийн эрхэм зорилго

Төрийн зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй боловсруулж, хэрэгжүүлэх болон төрийн алба, өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйлс, мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэх.

Хүний нөөцийн хөгжлийн стратеги

Музейн хүний нөөцийн удирдлагын хүрээнд дэвшүүлж буй стратегийн зорилтууд:

Нэг. Хүний нөөцийн цогц механизмыг төлөвшүүлэх

-Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулалт, удирдлагаар хангах

-Хүний нөөцийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ

Хоёр. Төрийн соёлын холбогдолтой зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх

-Байгууллагын үндсэн үйл ажиллагааны бүх албан тушаалтнуудад стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, бодлогын дүн шинжилгээ, мониторинг үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох арга хэмжээ авах, хэрэгжүүлэх болон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах

-Гүйцэтгэлийн удирдлагатай холбоотой дагаж мөрдөж буй музейн эрх зүйн актуудыг боловсронгуй болгох талаар холбогдох субъектэд санал, дүгнэлт гаргаж өгөх

Гурав. Удирдах түвшний албан тушаалтнуудын манлайллын чадавхийг хөгжүүлэх

Манлайлал гэдэг нь шаардлагатай харилцааг тогтоож, ажилтнуудын эрч хүч, авьяасыг дайчлан, тодорхой үр дүнд чиглүүлэхийн зэрэгцээ төрийн албаны үнэт зүйлс, ёс зүйг хүндэтгэх чадвар юм.

-Музейн салбарынхаа хэмжээнд стратегийн түвшинд бодож сэтгэх, зорилгодоо хүрэх арга замыг зөв тодорхойлж чаддаг байх

-Байгууллагын дотоод болон гадаад орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг буй болгох

-Бусадтай нөлөө бүхий ажлын харилцаа тогтоох, бусдыг уриалан дуудаж чаддаг байх

-Өөрийн биеэр үлгэрлэн өөрийгөө дайчлан, шударгаар ажиллах, бусдад урам хайрлаж, зоригжуулж чаддаг байх

-Бусдаар хүлээн зөвшөөрүүлж, үр дүнд хүрэх зэрэг гол чадварыг эзэмшсэн байх карьер өсгөх стратеги

Дөрөв. Албан хаагчдыг хөгжүүлэх, карьер хэрэгжүүлэх

-Мэргэшсэн, дадлага туршлагатай албан хаагчдаар баг бүрдүүлэх

-Музейн албан хаагчдыг шилж сонгох механизмыг боловсронгуй болгох

-Албан хаагчдыг сэлгэн ажиллуулах, карьер өсгөх тогтолцоог бүрдүүлэх

-Тухайн ажилтныг хөгжүүлэх хэрэгцээг байгууллагын тэргүүлэх чиглэл, өөрчлөлтөд уялдуулан тодорхойлох

Тав. Нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах иж бүрэн тогтолцоо бий болгох

-Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах чадавхи бий болгох

-Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх

-Шинээр ажилд орох ажилтнуудад шаардлагатай стандартын мэдлэг чадвар эзэмшүүлэх, тогтолцоотой болох

Зургаа. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах механизм төлөвшсөн байх

-Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, нөөцийг Нийслэлийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж талаар санал, санаачлага гаргах.

-Цалин хөлс, урамшууллын системийг өрсөлдөх чадвартай талаар Нийслэлийн удирдах байгууллагуудад санал, хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

-Ажлын байрны тохижилт, музейн шинэ барилга барих, шинэчлэлтийг орчин үеийн музейн стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

-Дээр дурьдсан арга хэмжээнүүдийг жил бүр байгууллага хариуцаж санхүүжүүлнэ.

Долоо. Ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх

Тус байгууллагын нийт албан хаагчид Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Авлигалын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сахин биелүүлдэг, байгууллагын стандартад тусгасан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж хэвшүүлэх нь байгууллагын үйл ажиллагаа, соёлын чухал үндэс гэж үзнэ.

----- Улаанбаатар хотын музей -----